БАТЛАВ

ЗАХИРАЛ В.АЛТАНСУВД

ХЭРЛЭН СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН **НЭГДМЭЛ** АГУУЛГЫН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ

Хугацаа- 60 минут Огноо: 2024.06.06 Анги ....... Сурагчийн нэр ........................

**МОНГОЛ ХЭЛ** **А хувилбар** **Нийт 30 оноо**

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**: Сонгох даалгавар бүр 1 оноотой

Унших чадварыг үнэлэх даалгавар: Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй

## ЭЦГИЙН ЗАХИАС

Ганц хүүтэй ядуу тариачин нас барахынхаа өмнө эхнэртээ “-Хүүгээ л эрдэмтэй сайн хүн болгоорой. Тэгвэл хүн бүхэн хүндэтгэнэ” гэж захижээ. Хүүг долоон нас хүрмэгц эх нь: -Одоо чи эцгийнхээ гэрээсийг биелүүлэх цаг нь болжээ. Чамд эрдэм сурах арван жилийн хугацаа өгье. Тэгснийхээ дараа хотод очиж шалгалт өгөөд, эрдэмтэн болж чадна” гэж хэлэв. Хүү хот руу явсан боловч хугацаанаасаа өмнө эргэж ирэхэд эх нь хүүгээ санасан хэдий ч сэтгэлээ барин: -Чи яагаад хугацаанаас өмнө ирэв? Шалгалт өгч чадахаар ном эрэм сурчхаа юу? гэж асуухад, хүү нь уйлж, “Идэх юм өгөөч.”гэв. -Би тандаа ирэх гэж яараад арван жил сурах эрдмийг наана нь сурчихсан гэхэд эх нь: -Тэгвэл чи эхний арван үсгийг харанхуйд бич гээд гэрлээ унтраахад, хүү ч үсгээ бичиж, эх нь боорцог хийжээ. Хүүгийн бичсэн үсгүүд том жижиг, хэд хэдэн газар бэх дусаасан байхад ээжийнх нь хийсэн боорцог цэв цэвэрхэн сайхан болсон байв. Ээж нь хүүгээ гэртээ байлгахыг хэчнээн их хүсэж байсан ч “-Эрдмээ өөрийн болгоод сураад ир.” гэж тэр шөнөдөө явуулжээ.

1. Хүү хугацаанаасаа өмнө ирдгийн учир юу вэ?
   A. Ихэд өлсөж ядарсан
   B. Ээждээ ирэхээр яарсан
   C. Сурах зүйлээ сайн сурсан
2. Ээж нь яагаад гэрлээ унтраасан бэ?
   A. Үсэг бичихэд хэцүү болгох гэж
   B. Хүүгээ буцааж эрдэм сурахаар явуулах гэж
   C. Төгс сайн сурсан байна уу гэж шалгахаар
3. Ээжийн хэлсэн “Эрдмээ өөрийн болгоод сураад ир” гэсэнд тохирох зүйр үгийг олж тэмдэглэ.
   A. Эрдмийг хичээлээр сурдаг, эрлийг сургаар олдог
   B. Ах нь хүндэлж, дүү нь сургадаг
   C. Хүн ахтай, дээл захтай
4. “Эцгийн захиас“ эхэд гарсан агуулгыг олж тэмдэглээрэй.
   A. Хүүгийн мунхгийн тухай
   B. Эцгийн захиасын тухай
   C. Эрдэм сурахын ашиг тусын тухай
5. Зөөлрүүлэх үүргээр орсон “Ь”-тэй үгийг олоорой.
   А. Харья Б. Хэлье В.бичье Г. харъя
6. “Багваахай” гэдэг үгэнд “-ны, -д, -оос, -оор, -той, -луу, -ийг” гэсэн залгавруудыг зөв залгасан хэсгийг олоорой
   А. Багваахайны багваахайтай багваахайд Б. Багваахайноос багваахайд багваахай луу
   В. Багваахайноос багваахайны багваахай луу

**ХОЁРДУГААР ХЭСЭГ: Задгай даалгавар**

1. Эцгийн захиасыг биелүүлэхээр суралцаж байгаа хүүд урилга бичээрэй /3 оноо/

………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………………

…………………………………………………………………………………………………
…………………………………………………………………………………………………
…………………………………………………………………………………………………
…………………………………………………………………………………………………
…………………………………………………………………………………………………

2. Дараах үгсийн утгыг тайлбарлаад, өгүүлбэр зохиож бичээрэй /3 оноо/
   Хэр…………………………………………………………………………………………
   Хир…………………………………………………………………………………………

.............................................................................................................................................

3. Хүний зан чанарыг илэрхийлсэн дараах үгсийн эсрэг утгатай үгийг олж бичээрэй /3 оноо/

Хүлээцтэй.......................

Ажилсаг..........................

Цухалдуу………………..

## ХҮН БА БАЙГАЛЬ

1. Араг яс биеийн тулгуур болохоос гадна............, биеийг хөдөлгөх үүрэгтэй.
   А.Дотор эрхтнүүдийг хамгаалах　　Б. Хөл дээрээ зогсох
   В. Арьс тогтоох　　Г. Булчин хөгжүүлдэг
2. Хүний гарын ясны хэсэгт аль нь хамааралгүй вэ?
   А.Бугалга　Б. Сарвуу　В. Бугуй　Г. Шуу
3. Дараах амьтдын үр төлийн нэрийг зөв харгалзуулсан өгөгдлийг сонгоорой
   А. Ямаа　Б. Туулай　В. Нохой　Г. Үнэг
   А. 1-ишиг, 2 бүжин, 3-гавар, 4- гөлөг　　В. 1-ишиг, 2-бүжин, 3-гөлөг, 4-гавар
   В. 1-ишиг, 2-гавар, 3-бүжин, 4-гөлөг　　Г. 1-ишиг, 2-гөлөг, 3-гавар, 4-бүжин
4. Өгөгдсөн зургийг сайтар ажиглаад аль нь шахагдсан хийг дүрсэлсэн зураглал болохыгсонгоно уу.




5. Ямар материал цахилгаан сайн дамжуулдаг вэ?
   А.Резин　Б. Төмөр　В. Даавуу　Г. Хуванцар
6. Аль бие нь соронзонд татагдах вэ?

1 

2 
3 
4 

А.1　Б.2　В.3　Г.4

**Хоёрдугаар хэсэг: Хүн ба байгаль задгай даалгавар**

7. Хүснэгтэд тохирох үгийг нөхөж бичээрэй /2 оноо/

| Орчиндоо зохицсон онцлогтой амьтан | Орчиндоо зохицсон онцлогтой ургамал |
|---|---|
| - Тэмээ<br>- ..................... | - Багваахай ургамал<br>- ........................... |

8. Амьд биеийн идэш тэжээлийг зөв харгалзуулаарай /2 оноо/
   1. Загас　　А.Замаг

2. Бар Б. Өвсөн
3. Туулай В.Мах
4. Цахлай Г.Загас

9. Алтан гадас одыг тэнгэрээс олж чадах уу? /2 оноо/

А. Хэрхэн олох аргаа бичээрэй. /1 оноо/

..............................................................................................................................................
..................................................................................................................................

Б. Дараах өгсөн зайд долоон бурхан одыг зураарай. /1 оноо/

| |
|---|
| |

10. Хийн шахагдах шинжийг тодорхойлох туршилтын үр дүнг ажиглаад зөв дүгнэлтийг бичээрэй /3 оноо/

| Туршилтын өмнө | Туршилтын дараа |
|---|---|
|   |   |

..............................................................................................................................................
..............................................................................................................................................
..............................................................................................................................................
..............................................................................................................................................
..............................................................................................................................................
...........................................................................................................................................

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР А.МӨНХЦЭЦЭГ

БАТЛАВ

ЗАХИРАЛ В.АЛТАНСУВД

ХЭРЛЭН СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН НЭГДМЭЛ АГУУЛГЫН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ

Хугацаа- 60 минут Огноо: 2024.06.06 Анги ....... Сурагчийн нэр .......................

**МОНГОЛ ХЭЛ** **Б хувилбар** **Нийт 30 оноо**

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**: Сонгох даалгавар бүр 1 оноотой

Унших чадварыг үнэлэх даалгавар: Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй

**АХ ДҮҮ ХОЁР**

Эрт цагт ах дүү хоёр тариа тарьж амьдран суудаг байжээ. Ах нь ганцаар, дүү нь долоон хүүхэдтэй, ам бүл олуулаа. Ах дүү хоёр эв найртай, хамтран ажиллаад, ургацаа адилхан хуваан авдаг байлаа.

Нэг өдөр ах нь “Тариагаа адилхан хуваaж авах нь зөв үү? Буруу юу? Дүү минь олон хүүхэдтэй, ам бүл олуулаа тул их талх хэрэгтэй. Дүүдээ нэг бухал тариа нэмж өгье” гэж бодоод өөрийн тарианаас нэг бухлыг аваад, дүүгийнхээ тариан дээр нэмж орхив. Тэр шөнө дүү нь эхнэртээ хэлсэн нь,

- Ахтайгаа тариагаа яг адилхан хуваан авдаг маань буруу юм байна. Ах ганцаараа суудаг. Гэрийн ажилд нь туслах хүн байхгүй юм. Ахад их тариа хэрэгтэй тул нэг бухлыг нэмж өгье гэв. Энэ үгийг сонсоод, эхнэр нь зөвшөөрсөнд нэг бухал тариаг ахдаа нэмж өгөв.

Маргааш өдөр нь үзвээс хэн хэнийх нь тариа яг тэнцүү хэвээрээ байсанд бие биедээ юу ч хэлэлгүй явцгаав. Ингэж хэдэн шөнө бие биедээ тариагаа шилжүүлсээр байжээ. Сүүлд учраа ярилцаж, хэн хэндээ туслах сайхан сэтгэлтэй байдгийг мэджээ.

1. Ах дүү хоёр юу хийдэг байсан бол?
   А. Эвтэй найртай хамт амьдардаг байсан
   Б. Тариа тарьж амьдардаг байсан
   В. Ах дүү хоёр амьдардаг байсан

2. Тарьсан ургацаа хэрхэн хуваaж авдаг байсан бэ?
   А. Ах нь ганцаараа тул багыг авдаг байсан
   Б. Дүү нь ам бүл оруулаа тул илүү бухлыг авдаг байсан
   В. Тарьсан тариагаа яг тэнцүү хуваан авдаг байсан

3. Ах дүү хоёр юугаараа адилхан байсан бэ?
   А. Ихэр юм шиг гадаад төрх нь адилхан
   Б. Ах дүү хоёр ажилсаг байсан
   В. Ах дүү хоёр хоёулаа сайхан сэтгэлтэй байсан

4.Цэгийн оронд нөхөж бичсэн эгшиг ямар үүрэгтэй болохыг сонгоно уу?

хал...м хув...н уд...рдсаар мур...лзуулсаар сон...н

А. эгшигжүүлэх Б. зөөлрүүлэх В. эгшигжүүлэх ба зөөлрүүлэх

5. Балархай эгшгийн үүргийг зөв холбосон хариултыг ороорой

| | |
|---|---|
| 1. шударга | А.Зөөлөрснийг тэмдэглэх үүрэгтэй |
| 2. найдвар | Б. Эгшигжүүлэх үүрэгтэй |
| 3. Анги | В. Ялгах үүрэгтэй |

А.1б, 2а,3в Б.2а, 3в, 1б В. 1в, 2б, 3а Г. 3в, 1б, 2а

6. я, е, ё” эгшгийг ямар үгэнд яаж залгадаг вэ? Зөв бичсэн бүлэг үгсийг олоорой.

А. явья, өгье бодъё бичье Б. Саная, эхэлье сонсъё уншъя

В. Аргадъя, асууя, учиръя, үзье Г. Хүргэе тусалъя харья харъё

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Задгай даалгавар

Ажилсаг, сайхан сэтгэлтэй ах дүү хоёрын тухай мэдээ бичээрэй /3 оноо/

…………………………………………………………………………………………………

…………………………………………………………………………………………………

……………………………………………………………………………………………………
……………………………………………………………………………………………………
……………………………………………………………………………………………………
……………………………………………………………………………………………………
………………………………………………………………………………………

Дараах үгсийн утгыг тайлбарлаад, өгүүлбэр зохиож бичээрэй /3 оноо

Ид……………………………………………………………………………………………
Эд……………………………………………………………………………………………
……………………………………………………………………………………………………
………………………………………………......................................................................................

Хүний зан чанарыг илэрхийлсэн дараах үгсийн эсрэг утгатай үгийг олж бичээрэй /3 оноо/

Олон зантай -....................

Цухалдуу ...........................

Хүлээцтэй ………………….

## ХҮН БА БАЙГАЛЬ

1. Араг яс биеийн тулгуур болохоос гадна, дотор эрхтнүүдийг хамгаалах, ………үүрэгтэй.
   А.Арьс тогтоох Б. Хөл дээр зогсоох
   В. Биеийг хөдөлгөх Г.Булчин хөгүүлдэг
2. Хүний гарын ясны хэсэгт аль нь хамаардаг вэ?
   А. Дух Б.Сүүж В.Шилбэ Г.Шуу
3. Дараах амьтдаас аль нь сүүн тэжээлтэн бэ?
   А. Гүрвэл Б. Оцон шувуу В. Буга Г. Аварга загас
4. Дараах өгөгдлөөс цахилгаан дамжуулдаггүй биетийг сонгоно уу?
   А. Лаазны буддаггүй хэсэг Б: Төмөр сэрээ
   Б. Хөнгөн цагаан Г. Хуванцар сэрээ
5. Хатуу биеийн жижиг хэсгүүдийг харуулсан зураг аль нь вэ?

   А. 1
   Б. 2
   В. 3
   Г. 1 ба 3




6. Дараах өгөгдлөөс цахилгаан дамжуулдаг хэсгийг олоорой

   А. Лаазны будагтай хэсэг, хуванцар сэрээ, төмөр хавчаар, дэвтрийн цаас

   Б. Төмөр сэрээ, бүрээстэй хавчаар, харандааны бал, хуванцар халбага

   В. Хайчны төмөр хэсэг, төмөр хавчаар, харандааны бал, зэс бугуйвч

   Г. Аль нь ч биш

**Хоёрдугаар хэсэг: Хүн ба байгаль задгай даалгавар**

7. Хүснэгтэд тохирох үгийг нөхөж бичээрэй  /2 оноо/

| Орчиндоо зохицсон онцлогтой амьтан | Орчиндоо зохицсон онцлогтой ургамал |
|---|---|
| - Тэмээ<br>- .................... | - Багваахай ургамал<br>- .......................... |

8. Амьд биеийн идэш тэжээлийг зөв харгалзуулаарай /2 оноо/

1. Сохор номин А.Мах
2. Чоно Б. Самар
3. Хэрэм В. Үндэс
4. Зөгий Г.Цэцэг

9. Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй /2 оноо/

А. ………………, ………….., ……………зэрэг металлууд нь цахилгаан дамжуулж байгаа учраас …………… ……………………юм.

Б. ………….., ……………., ……………….зэрэг биетүүд нь цахилгаан дамжуулж чадахгүй байгаа учраас …………………. ……………………юм.

10. Хийн шахагдах шинжийг тодорхойлох туршилтын үр дүнг ажиглаад зөв дүгнэлтийг бичээрэй /3 оноо/

| Туршилтын өмнө | Туршилтын дараа |
|---|---|
|   |   |

...................................................................................................................................................
...................................................................................................................................................
...................................................................................................................................................
...................................................................................................................................................
...................................................................................................................................................
...................................................................................................................................

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР А.МӨНХЦЭЦЭГ

**ХЭРЛЭН СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-204 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 4 ДҮГЭЭР АНГИЙН АНГИ ДЭВШИХ НЭГДМЭЛ АГУУЛГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН СХЕМ**

| Даалгаврын № | Суралцахуйн зорилт | Үнэлгээний зорилт | А хувилбар | Б хувилбар | Оноо | Онооны тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Монгол хэл** | | | | | | |
| **НЭГ. УНШИХ ЧАДВАРЫН СОНГОХ ДААЛГАВАР** | | | | | | |
| 1 | 4.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах<br>4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих | Мэдлэг ойлголт | А | Б | 1 | Зөв хариултыг сонгосон бол 1 оноо, буруу хариулт сонгосон бол 0 оноо, огт хариулт сонгоогүй бол Х оноо |
| 2 | | Мэдлэг ойлголт | С | В | 1 | |
| 3 | | Мэдлэг ойлголт | А | В | 1 | |
| 4 | | Чадвар | С | В | 1 | |
| 5 | | Чадвар | А | В | 1 | |
| 6 | 4.2г. Хатуу, зөөлний тэмдгийн тусгаарлах үүргийг мэдэх, зөв бичих | Чадвар | А | В | 1 | |
| **БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР** | | | | | | |
| 1 | 4.2и. Хүндэтгэлийн үг хэрэглэн, бүтцийн дагуу урилга бичих<br>4.2з. Өгсөн асуултын хүрээнд үйл явдлын товч мэдээ бичих | Чадвар | Эхлэл- Хүндэтгэсэн үг, нэр<br>Гол- Эрдэм номын тухай үйл ажиллагаанд урьж байгаа тухай, хүүхдээс өөр санаа гарч болно | Эхлэл- Хүндэтгэсэн үг, нэр<br>Гол- Хүүгийн эрдэм сурахаас явсан тухай. Эрдэм сурахын ашиг тусыг аав ээж нь хүүдээ ойлгуулж байгаа тухай | 3 | Урилга, мэдээ бичихдээ бүтцийг гаргасан бол 1 оноо, хүндэтгэлийн үг хэрэглэн бүтцийн дагуу урилга бичихдээ ойлгомжтой, алдаагүй, зөв, хичээнгүй |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 4.2а. Дуудлага ижил зарим үгийг утга, бичлэгээр нь ялгаж, өгүүлбэрт зөв хэрэглэх (буурь-буйр, хууль-хуйл, тууль-туйл) | | Төгсгөл- Урьсан хүний нэр, газын хаяг, хобогдох утас | Төгсгөл- мэдээг бэлтгэсэн хүний нэр, албан ажлын нэр | | бичиж чадсан бол 1 оноо, алдаатай бол алдаатай үг бүрээс 0.1 оноо хасаж тооцно. Буруу бичсэн бол 0 оноо, огт бичээгүй бол Х оноо |
| | | Чадвар | Хэр хэмжээ, хир буртаг | Идэх уух, эд хөрөнгө | 3 | Үгийн утгыг зөв гаргаж тайлбарласан бол үг тус бүр 1 оноо, үгийн утгыг зөв гаргасан өгүүлбэр зохиосон бол 1 оноо, буруу хийсэн бол 0 оноо, огт хийгээгүй бол Х оноо |
| | | Хэрэглээ | Яаруу, залхуу, тайван | Нэг зангаараа, уужуу, | | |
| **ХҮН БА БАЙГАЛЬ** | | | | | | |
| 1 | 4.1.1. Сурагч хүний хөдөлж буй зарчим, зарим амьд биеийн онцлог шинж нь амьдрах орчинтойгоо зохилдсон болохыг тайлбарлаж чаддаг болно. | мэдлэг ойлголт | А | В | 1 | Зөв хариулсан хариулт бүр 1 оноо, буруу хариулсан бол 0 оноо, огт хариулаагүй бол Х оноо |
| 2 | | мэдлэг ойлголт | В | Г | 1 | |
| 3 | | Мэдлэг ойлголт | В | В | 1 | |
| 4 | 4.1.2. Сурагч хүрээлэн буй орчин дахь өөрчлөлтийн шалтгааныг хүний үйл ажилллагаатай холбон тайлбарладаг болно. | Мэдлэг ойлголт | А | Г | 1 | |
| 5 | | Чадвар | Б | В | 1 | |
| 6 | | Чадвар | Г | В | 1 | |
| **Хүн ба байгаль - Задгай даалгавар** | | | | | | |
| 7 | | Чадвар | гүрвэл | Заг | 2 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | 4.1.1. Сурагч хүний хөдөлж буй зарчим, зарим амьд биеийн онцлог шинж нь амьдрах орчинтойгоо зохилдсон болохыг тайлбарлаж чаддаг болно. | Чадвар | Загас- замаг<br>Бар- мах<br>Туулай -өвс<br>Цахлай- загас | Сохор номин- үндэс<br>Чоно-мах<br>Хэрэм-самар<br>Зөгий-цэцэг | 2 | Тус бүр 0.5 оноо, буруу холбосон бол 0 оноо, огт хариулаагүй бол X оноо |
| 9 | | Чадвар | Луужингаар хийд зүгийг олох, алтангадас од нь  хөдөлгөөнгүйгээр дэлхийн тэнхлэгийн дагуу хойд зүгийг зааж байдаг. Иймд уг одны тусламжтайгаар ямар ч луужингаас илүү, алдаа мадаггүйгээр хойд зүгийг хялбархан олж болно | Хөнгөн цагаан, зэс, төмөр зэрэг нь цахилгаан дамжээлж байгаа учраас металь юм.<br>Мод, даавуу, хуванцараас бүтсэн биетүүд гь цахилгаан дамжуулж чадахгүй байгаа учраас металь биш юм. | 2 | Зөв хариулсан хариулт бүр 1 оноо, зөв зурсан зураг 1 оноо, буруу хариулсан бол 0 оноо, огт хариулаагүй бол X оноо |
| 10 | 4.1.2. Сурагч хүрээлэн буй орчин дахь өөрчлөлтийн шалтгааныг хүний үйл ажилллагаатай холбон тайлбарладаг болно. | Хэрэглээ | Хийн жижиг хэсгүүд хоорондоо хол байрладаг учраас шахагддаг | | 3 | Утгыг зөв гаргаж хариулсан бол 3оноо, буруу хариулсан бол 0 оноо, огт хариулаагүй X оноо |